



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/23

Мөрөн сум

Мах, сүүний чиглэлийн бухан бяруу
хүлээн авах комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2026 оны 03 сарын 13-ны өдрийн А/51 тоот захирамжаар байгуулагдсан Сумын үнэлгээний хорооны 2025 оны 03 сарын 27-ны өдрийн 06 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.


1. Иргэн (Х.Төгөлдөр) нь сумын ОНХ сангийн хөрөнгө оруулалтаар “Мах, сүүний чиглэлийн бухан бяруу” худалдан авч нийлүүлэх ажлын тендерт ялж 2026 оны 03 сарын 30-наас 2026 оны 11 сарын 01-ний дотор хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан тул уг ажлын явцад хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хүлээн авах эрх бүхий сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	С.Сүхчулуун	Зөөлөн багийн Засаг дарга
Гишүүдэд:	Б.Долгорнямаа	ЖДҮХХ-мэргэжилтэн
	А.Энхтөр	Аж ахуйн нярав
	Р.Төрбадрах	“Зөөлөн булаг”-ххк малын эмч
	Н.Эрдэнэ-Оюун	“Ариун лэн”-ххк малын эмч

2. Иргэн (Х.Төгөлдөр)-өөс “Мах, сүүний чиглэлийн бухан бяруу” худалдан авах ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн нас, хүйс, тарга тэвээрэг, амьдын жин, өвчин эмгэг, вакцинд хамрагдсан байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авах, цаашид яаж ашиглах талаар санал боловсруулж СӨХБЗөвлөлд танилцуулахыг комиссын дарга (С.Сүхчулуун)-д үүрэг болгосугай.

3."Мах, сүүний чиглэлийн бухан бяруу" хөрөнгөнд бүртгэх, цаашид яаж ашиглах талаар комиссын дарга саналыг үндэслэн журам боловсруулж СӨХБЗөвлөлөөр батлуулж ажиллахыг нягтлан бодогч (Т.Баяртуяа), Байгууллагын эмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Ц.Болорцэцэг) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ